



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10, 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 3.12 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 3.12 дахь хэсэг:

“ТЗК-ийн үйл ажиллагааг ТУЗ удирдаж, хяналт тавих бөгөөд энэхүү үүргийг тодорхой гэрээний дагуу бусад этгээдээр гүйцэтгүүлж болно. ТУЗ-ийн гишүүн нь 3 болон түүнээс дээш байх ба нийт гишүүдийн олонхи нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсэгт заасан шаардлага хангасан хараат бус этгээд байна”.

2. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.13 дахь хэсгийн “бусад” гэсний дараа “гурваас дээшгүй” гэж нэмсүгэй.

3. Мөн журмын 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.4.3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

4. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000618